БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

# АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2014 ОНЫ II УЛИРЛЫН ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ

2014 он

# АГУУЛГА


| № | Тогтоолын тэргүү | Огноо, дугаар | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Албан татварын хэмжээ шинэчлэн тогтоох тухай | 2014.04.07, № 46 | 4 |
| 2 | Журам батлах тухай | 2014.04.07 № 47 | 6 |
| 3 | Журам шинэчлэн батлах тухай | 2014.04.07 № 48 | 14 |
| 4 | Нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицол батлах тухай | 2014.04.16 № 54 | 21 |
| 5 | Тогтоолд нэмэлт оруулах тухай | 2014.05.06 № 66 | 37 |
| 6 | Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай | 2014.06.18 № 87 | 39 |
| 7 | Тогтоолд нэмэлт оруулах тухай | 2014.06.27 № 97 | 40 |

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.04.07 № 46 Номгон

## Албан татварын хэмжээ шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Баянхонгор аймгийн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Тогтоолыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 42 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014
оны 46 дугаар тогтоолын хавсралт

## БАЯНХОНГОР АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

| № | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл | | Жилд ногдуулах албан татварын хэмжээ /₮/ |
|---|---|---|---|
| 1 | 2 дугуйтай мотоцикль | | 2500 |
| 2 | 3 дугуйтай мотоцикль | | 3000 |
| 3 | Суудлын автомашин | 3. 2001 см3 хүртэл | 18 |
| | | 4. 2001-3001 см3 хүртэл | 20 |
| | | 5. 3001 см3 болон түүнээс дээш | 28 |
| 4 | Микроавтобус /15 хүртэл суудалтай/ | | 40000 |
| 5 | Автобус | | 60000 |
| 6 | Ачааны автомашин | 1 хүртэл тн-ийн даацтай | 25000 |
| | | 1-2 тн-ийн даацтай | 35000 |
| | | 2-3 тн-ийн даацтай | 45000 |
| | | 3-5 тн-ийн даацтай | 55000 |
| | | 5-8 тн-ийн даацтай | 90000 |
| | | 8-10 тн-ийн даацтай | 100000 |
| | | 10-20 тн-ийн даацтай | 110000 |
| | | 20-30 тн-ийн даацтай | 165000 |
| | | 30-40 тн-ийн даацтай | 220000 |
| | | 40-50 тн-ийн даацтай | 280000 |
| | | 50-60 тн-ийн даацтай | 320000 |
| | | 60-70 тн-ийн даацтай | 400000 |
| | | 70-80 тн-ийн даацтай | 420000 |
| | | 80-90 тн-ийн даацтай | 480000 |
| | | 90-100 тн-ийн даацтай | 500000 |
| | | 100 тн-оос дээш | 550000 |
| 7 | Тусгай зориулалтын автомашин | | 22500 |
| 8 | Трактор, өөрөө явагч хэрэгсэл | | 14000 |
| 9 | Бага оврын трактор | | 7000 |
| 10 | Чиргүүл /даацын 1 тн тутамд/ | | 7000 |
| | **Нийт** | | |

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.04.07 № 47 Номгон

## Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Сумдын ИТХ-ын ажил дүгнэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг ажлын алба /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
47 дугаар тогтоолын хавсралт

# СУМДЫН ИТХ-ЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ

## Нэг. Ерөнхий зүйл

**ЗОРИЛГО НЬ:** Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, багийн ИНХ болон сумдын ИТХ-ын ажлыг жигд сайжруулах, нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тэдгээрийн ажлыг үнэлж урамшуулахад оршино.

## Хоёр. Зохион байгуулалт

2.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас дараах хуваарийн дагуу сумдыг хариуцан ажиллана.

1. Богд, Жинст, Баянлиг, Баянговь
   Ц.Мөнхжаргал
2. Баянцагаан, Баацагаан, Баян-Өндөр, Баацагаан
   Л.Доржханд
3. Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Хүрээмарал
   Ц.Байгальмаа
4. Галуут, Заг, Жаргалант, Гурванбулаг
   Ц.Мөнхзул
5. Баян-Овоо, Өлзийт, Эрдэнэцогт
   Д.Юндэнбазар
6. Баянхонгор
   Д.Ширмэн

2.2 Сумдын ажлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс томилогдсон ажлын хэсэг жилд нэгээс доошгүй удаа явж хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу шалгана.

2.3 Дээрх ажлын хэсгийн шалгалтын дүн болон сумдаас ирүүлсэн тайланд өгсөн дүнг нэгтгэн Тэргүүлэгчдийн хурлаар

хэлэлцүүлж эцсийн дүнг гаргана.

2.4 Ажлын алба /дарга, мэргэжилтнүүд/ хариуцсан сумдын ИТХ-даа мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, шаардлагатай гарын авлага материалаар хангаж ажиллана.

**Гурав.Тайлан гаргаж ирүүлэх хугацаа, түүнийг дүгнэх**

3.1 Сумын ИТХ-аас хагас, бүтэн жилээр сүүлийн сарын 25-ны дотор ажлын тайлангаа гарган ирүүлнэ.

3.2 Тайланд үндэслэн Сумын ИТХ-ын ажлыг дараа сарын 10-ны дотор багтаан хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу аймгийн ИТХ-ын ажлын алба дүнг нэгтгэн Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.

3.3 Тухайн жилийн эцэст дүнг нэгтгэн оноогоор нь байр эзлүүлж журманд заасан урамшууллыг олгоно.

**Дөрөв. Ажлыг дүгнэж, хариуцлага тооцох**

4.1 Ажлынхаа тайланг ирүүлээгүй болон шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, дарга, нарийн бичгийн дарга нарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж, сумын иргэдэд дүнг танилцуулна.

**Тав. Сумын ИТХ-ын үйл ажиллагааг дүгнэж урамшуулал олгох зарчим**

5.1 Хавсралт үзүүлэлтийн дагуу сумын ИТХ-ын гаргаж ирүүлсэн тайланг аймгийн ИТХ-ын ажлын алба дүгнэж оноо өгнө.

5.2 Тухайн сумын ИТХ нь

90-100 оноо авбал “Маш сайн” буюу A

80-89 оноо авбал “Сайн” буюу B

70-79 оноо авбал “Хангалттай” буюу C

60-69 оноо авбал “Дутагдалтай” буюу D

0-50 оноо бол “Хангалтгүй” буюу F гэсэн үнэлгээг тавина.

5.3 Журмын 2.2-т заасан ажлын хэсгийн өгсөн үнэлгээг

харгалзан дүгнэнэ.

5.4 Жилийн эцэст хавсралт үзүүлэлтийн дагуу дүгнэн авсан оноогоор байр эзлүүлэн эхний гурван байранд орсон сумын ИТХ-ыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Үүнд: I байр -800000 төгрөг

II байр -600000 төгрөг

III байр-400000 төгрөг

**Зургаа. Бусад зүйл**

6.1 Энэхүү журмаар олгогдох өргөмжлөл, мөнгөн шагналыг жил бүрийн аймгийн ИТХ-ын төсвийн холбогдох зардлын зүйлд тусган батлуулна.

6.2 Шаардлагатай тохиолдолд журманд өөрчлөлт оруулж болно.

--------------------oOo------------------------

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
47 дугаар тогтоолын хавсралт

## СУМДЫН ИТХ-ЫН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Сумын нэр.....................................

| № | Ажил дүгнэх чиглэл | Харгалзах үзүүлэлт | Оноо | Авсан оноо |
|---|---|---|---|---|
| 1 | Дотоод ажил | Хурлын байгууллагын баримтлах үндсэн чиглэл, түүний боловсруулалт | 0-2 | |
| | | Жил, улирлын төлөвлөгөөний боловсруулалт, төлөвлөгөөнд тусгасан бодит ажлын үр дүн, биелэлтийг тооцсон байдал | Үзүүлэлт тус бүр 0-2 хүртэл оноо | |
| | | Албан хэрэг хөтлөлт, стандарт хангалт<br>• Тухайн жилд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт үйлдэж, батлуулан мөрдөж байгаа эсэх<br>• Албан бичиг, баримтын стандарт, боловсруулалт<br>• Тогтоол шийдвэрийн биелэлт, хугацаатай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж буй байдал<br>• Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /бүртгэл хөтлөлт, шийдвэрлэлтийн хувь/<br>• ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын тогтоолын эрх зүйн зөрчил<br>• Ажлын байрны тодорхойлолт, түүний боловсруулалт<br>• Үр дүнгийн гэрээ байгуулж үр дүнг тооцсон байдал | | |
| ДҮН | | | 18 | |
| 2 | Хуралдаан | • Хуралдааны байнгын дэгтэй эсэх / хуралдааны явц байдлыг бүрэн тусгаж аливаа асуудлыг шийдвэрлэх гарцуудыг зааж чадсан эсэх/<br>• Хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн дундаж ирц<br>• Хэлэлцүүлсэн асуудлын оновчтой байдал<br>• Бодлогын шинжтэй шийдсэн асуудлын тоо<br>• Хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, үр дүн<br>• Хуралдаан хийсэн тоо<br>• Хуралдааны материал ирүүлж хянуулсан байдал | Үзүүлэлт тус бүр 0-2 хүртэл оноо | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ДҮН | | | | | 14 | |
| 3 | Тэргүүлэгчдийн хуралдаан | • Тэргүүлэгчдийн хурлын ирц бүрдэлт<br>• Хэлэлцүүлсэн асуудлын оновчтой байдал<br>• Хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, үр дүн тооцсон эсэх<br>• Тэргүүлэгчдээс санаачлан боловсруулж батлуулсан асуудал<br>• Хуралдаан хийсэн тоо<br>• Бодлогын шинжтэй шийдвэрийн тоо<br>• Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны мэдээ ирүүлсэн эсэх | | | Үзүүлэлт тус бүр 0-2 хүртэл оноо | |
| 4 | Төлөөлөгч, Тэргүүлэгч, ажлын хэсэг хороодтой ажиллах талаар | Төлөөлөгчдийг тойрогт нь ажиллуулж, түүний тайланг нь хэлэлцүүлсэн байдал, иргэдийн санал хүсэлтийг авсан эсэх | | | 0-2 оноо | |
| | | Тэргүүлэгчдийн ажлыг дүгнэж, урамшуулал олгосон эсэх | | | 0-2 оноо | |
| | | Байнгын хороо, ажлын хэсэг, хороо ажиллуулсан байдал болон тэдний ажлыг дүгнэсэн байдал | | | 0-2 оноо | |
| 5 | Өмч хөрөнгө, төсөв санхүүтэй холбоотой ажлууд | Сумын төсөвт байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын тайланг гуравдугаар улиралд багтааж хэлэлцсэн эсэх | | | 0-2 оноо | |
| | | Тухайн жилийн хурлын төсөв, санхүүд хийгдсэн аудит, мэргэжлийн хяналтын газрын дүн | | | 0-2 оноо | |
| | Аймаг, сумын ИТХ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхээр сурталчилсан байдал, үр дүн | Сурталчилсан хэлбэр | Сурталчилсан тоо | Хамрагдсан хүний тоо | Үзүүлэлт тус бүрээр 0-2 оноо | |
| | | Багийн ИНХ-аар | | | | |
| | | Мэдээллийн самбараар | | | | |
| | | Гарын авлагаар | | | | |
| | | Уулзалт, хурал цуглааны үеэр | | | | |
| | | Телевиз, радио, | | | | |
| | | бусад | | | | |
| ДҮН | | | | | 20 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил | Гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж тооцоо судалгаанд үндэслэн гэмт хэргийн нөхцөл шалтгааныг арилгах талаар хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, үр дүн биелэлтийг тооцсон байдал | 0-2 | |
| | | Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангахад байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хөрөнгийн хэлбэр харгалзахгүйгээр энэ ажилд татан оролцуулсан байдал | 0-2 | |
| | | Урьдчилан сэргийлэх чиглэлээр үзлэг шалгалт, сургалт зохион байгуулсан байдал | 0-2 | |
| | | Архидан согтуурахтай тэмцэх ажлын талаар хийж хэрэгжүүлсэн ажил | 0-2 | |
| | | Хөдөлгөөний аюулгүй байдал, Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн ажил | 0-2 | |
| | | Хулгайн болон мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн ажил | 0-2 | |
| | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын тайлан, мэдээг улирал бүр ирүүлсэн байх | 0-2 | |
| 8 | ХАСХОМ-ийн мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа | Тайланд хамрагдах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг үнэн зөв, хугацаанд нь гаргасан байдал /шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэсэн байх/ | 0-2 | |
| | | Мэдүүлэг гаргагчдаас мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулж, бүрэн хамруулсан байдал | 0-2 | |
| | | Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв, хуулийн хугацаанд, маягтын дагуу ирүүлсэн, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай болон бусад бүртгэлийг бүрэн хөтөлсөн байдал | 0-2 | |
| | | Мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийг цахим хэлбэрээр авч бүрэн баталгаажуулсан эсэх | 0-2 | |
| | | “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн программ” дахь “ЭБАТ” цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтөлсөн эсэх | 0-2 | |
| | | Мэдүүлэг гаргагч нарт сургалт зохион байгуулж, гарын авлага, заавар зөвлөмж өгсөн байдал | 0-2 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг сумын хэмжээнд гаргаж, тухайн мэдээллийг нээлттэй болгох | 0-2 | |
| | | Давхар ажил эрхлэлттэй холбоотой судалгаа сумын хэмжээнд гаргаж, тухайн мэдээллийг нээлттэй болгох | 0-2 | |
| | | ХАСХОМ-ийн бүртгэлийн дэвтэр хөтөлсөн байдал | 0-2 | |
| 9 | Шагнал, урамшуулал | Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулах журмын дагуу шагналын материалыг ирүүлсэн байдал | 0-2 | |
| 10 | **Дүн** | | **34** | |
| 11 | **Нийт оноо** | | **100** | |

-----------------oOo----------------

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
## ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.04.07 № 48 Номгон

**Журам шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Журмыг чанд мөрдөж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 100 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
48 дугаар тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЖУРАМ

1.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг хуралдуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын хуралдааны дэгд нийцүүлэн энэхүү журмыг мөрдлөгө болгоно.

**Хоёр. Тэргүүлэгчдийн хуралдааныг зарлах, хуралдаанд бэлтгэх**

2.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нэгтгэж, боловсруулан ИТХ-ын даргад танилцуулж, зөвшөөрөл авна

2.2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг сар бүр хуралдуулах бөгөөд дараа сарын хуралдах товыг ИТХ-ын дарга товлож, захирамж гарган хэлэлцэх асуудлыг батална. ИТХ-ын даргаас хэлэлцэх асуудалд оруулахаар албан ёсоор зөвшөөрсөн асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна.

2.3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас Тэргүүлэгчдийн хуралдаан хуралдах цаг хугацаа, байр, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, төслийг цаасаар болон онлайн хэлбэрээр хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө Тэргүүлэгчдэд албан ёсоор мэдэгдэж хүргүүлнэ.

2.4 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй.

2.5 Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал оруулах байгууллага, албан тушаалтан хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон асуудал бүр дээр дэлгэрэнгүй буюу товч илтгэл танилцуулга, гарах шийдвэрийн төслийг бэлтгэж, 10-аас доошгүй хоногийн өмнө Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

2.6 Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох бэлтгэл ажлыг хурлын ажлын алба бүрэн хангаж,

хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг хуульд нийцүүлэн боловсруулж бэлэн болгосон байна.

2.7 Хуралд хэлэлцэх асуудалтай холбогдуулан бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд оролцох үүрэгтэй. Бусад оролцогчдын нэрсийг ажлын алба гаргаж ИТХ-ын даргад танилцуулан, хуралдааны зарыг хүргэнэ.

2.8 Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, газар, алба, Засаг даргын дэргэдэх агентлагуудаас хэлэлцүүлэхээр оруулсан асуудалд Аймгийн Засаг дарга, түүний эзгүйд Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын даргын аль нэгийг байлцуулна.

2.9 Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, бодлогын хороо, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдээс хэлэлцүүлэхээр ирүүлсэн санал, материалд туссан зарчмын асуудлаар шаардлагатай гэж үзвэл Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын даргын аль нэгний санал, дүгнэлтийг авч болно.

2.10 Хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулж буй асуудалтай холбогдуулан Тэргүүлэгч, бодлогын хороо, Ажлын албанаас санал, дүгнэлт бэлтгэн оруулж болно.

2.11. Тэргүүлэгчид хэлэлцэх асуудал, гарах шийдвэртэй нэг бүрчлэн танилцаж, саналаа бэлтгэж, хуралд ажил хэрэгч, идэвхитэй оролцоно.

2.12. Дээрх шаардлагыг хангаагүй асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэхгүй.

## Гурав. Тэргүүлэгчдийн хуралдаан

3.1. Хуралдаанд Тэргүүлэгчдийн олонхи хүрэлцэн ирснээр хурлын ирцийг хүчинтэйд тооцож, хуралдааныг нээнэ.

3.2. Хуралдааныг ИТХ-ын дарга, түүний эзгүйд даргын санал болгосон аль нэг Тэргүүлэгч удирдана.

3.3. Хуралдааныг хэлэлцэх асуудлын ач холбогдол, гарах шийдвэрийн үр дүнг харгалзан иргэд, төлөөлөгч, мэргэжилтэн /нарийн мэргэжлийн/, аймгийн Засаг даргын зөвлөлийг оролцуулан өргөтгөсөн буюу нээлттэй хэлбэрээр хуралдуулж болно.

3.4. Шаардлагатай тохиолдолд Хуралдааныг Ажлын бус цагаар

хуралдуулж болно.

3.5. Тэргүүлэгчдийн хуралдааны хуралдах хугацааг хэлэлцэх асуудлын цар хүрээ, тоо хэмжээг харгалзан ИТХ-ын дарга тогтооно.

3.6. Тэргүүлэгчдийн хуралдааныг ажлын шаардлага хэлэлцэх асуудлын цар хүрээг харгалзан аль нэг албан байгууллага, аж ахуйн нэгж, сумд очиж зохион байгуулж болно.

3.7. Тэргүүлэгч өвчтэй байсан, өвчтэй хүн асарсан, гадаад, дотоодод томилолтоор явсан, бусад хурал семинарт зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд эдгээр шалтгаан байхгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

3.8. Тэргүүлэгч хуралдаан орхиж гарсан тохиолдолд түүнийг хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна

3.9 Хуралдаанд оролцож амжаагүй Тэргүүлэгч тухайн хуралдааны материалтай танилцаж болно.

3.10. Тэргүүлэгчдийн хуралдаан, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр ард иргэдэд ил тод нээлттэй байна.

**Дөрөв. Хуралдааны зохион байгуулалт**

4.1. Тэргүүлэгчдийн хуралдааныг аймгийн ИТХ-ын даргын өрөө болон иргэний танхимд зохион байгуулна. Асуудал оруулж байгаа болон уриалгаар оролцож байгаа хүмүүсийн суудал тусдаа байна.

4.2. Хуралдааныг ИТХ-ын дарга буюу хуралдаан даргалагч хэлэлцэх асуудлыг дараалал нэг бүрээр хэлэлцүүлж, шийдвэрийг батлсны дараа дараагийн хэлэлцэх асуудалд шилжинэ.

4.3. Тэргүүлэгчдийн хуралдаан 90 минут тутамд завсарлах бөгөөд завсарлага, хуралдааныг сунгаж хуралдах асуудлыг хуралдаан даргалагч Тэргүүлэгчдийн саналыг авч шийдвэрлэнэ.

4.4. Хуралдааны үеэр Тэргүүлэгчид, асуудал оруулагч, урилгаар оролцогчид бусдыгаа хүндэтгэж утсаа унтраана.

4.5. Хуралдааны явцад Тэргүүлэгч хуралдаанаас түр гарах зөвшөөрлийг хуралдааны даргаас авна.

4.6. Тэргүүлэгчид хуралдаанд орох асуудалтай урьдчилан танилцаж, санал дүгнэлтээ гаргаж өгснөөр уг Тэргүүлэгчийг

хуралдаанд оролцсоноор тооцож чөлөөлж болно.

4.7. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байхгүй боловч нэн яаралтай хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарвал Тэргүүлэгчдийн саналыг авч, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж хэлэлцэж болно.

4.8. Асуудал оруулж байгаа албан тушаалтан илтгэл, сонсгол, мэдээлэл, гарах шийдвэрийн төслөө танилцуулна.

4.9. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж буй асуудалд ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд мэдэгдэл бөглөх бөгөөд ашиг сонирхолын зөрчилтэй гэдгээ мэдэгдэн тухайн ашиг сонирхолын зөрчилтэй асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааныг түр орхино.

4.10. Тэргүүлэгчид хэлэлцсэн асуудалтай холбоотой асуултыг хуралдааны даргын зөвшөөрөлтэй асууж мэдээлэл авна.

4.11. Асуулт хариултыг тасалсны дараа Тэргүүлэгчид санал шүүмжлэл гаргана. Санал шүүмжлэл нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой товч тодорхой байна. Урилгаар оролцогчид хуралдааны даргаас зөвшөөрөл авч мөн асуудалтай холбоотой санал хэлж болно.

4.12. Тэргүүлэгчдийн гаргасан санал, шийдвэрийн төслийг хэлэлцэж олонхийн саналаар батална. Аймгийн төсөв, хөрөнгө, санхүүтэй холбоотой асуудлыг Тэргүүлэгчид аймгийн Засаг даргатай зөвшилцөж шийдвэрлэж болно.

4.13. Тэргүүлэгчдийн хуралдааныг шаардлагатай гэж үзвэл хаалттай хийж болно. Энэ шийдвэрийг ИТХ гаргах бөгөөд Тэргүүлэгчид хувийн саналаа илэрхийлэн дэмжлэг авч болно.

4.14. Эцэслэн шийдвэрлэгдээгүй асуудал, нууцлалтай холбоотой болон байгууллага, албан тушаалтан, иргэдтэй холбоотой онцлог бусад мэдээллийг тараах, бусдад мэдээлэхийг хориглоно.

**Тав. Тэргүүлэгчдийн хуралдааны явцыг баримтжуулах, архивлах, мэдээлэх**

5.1. ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны дотоод асуудал хариуцсан ажилтан буюу хуралдааны тэмдэглэл хөтлөгч тухайн

хуралдааныг баримтжуулах ажлыг ИТХ-ын нарийн бичгийн даргын хяналтын дор хариуцна.

5.2. Хуралдааны тэмдэглэлд: хуралдаан эхэлсэн, дууссан он сар, өдөр, цаг, хуралдаанд оролцсон Тэргүүлэгчид, оролцоогүй Тэргүүлэгчдийн шалтгаан урилгаар оролцогчид, хуралдаан даргалагч, хуралдааныг хийсэн газар, хэлэлцсэн асуудал, түүнтэй холбоотой гарсан санал шүүмжлэл, гаргасан шийдвэр зэргийг тодорхой бичнэ. Хуралдааны тэмдэглэл бичсэн ажилтан, хянасан хуралдаан даргалагчийн гарын үсэг зурснаар баталгаажна.

5.3. Тэмдэглэлд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой гарсан асуулт хариулт, санал шүүмжлэл, гарсан дүгнэлт, шийдвэрийг баталгаажуулахад зөвшөөрсөн, татгалзсан Тэргүүлэгчдийн талаар нэг бүрчлэн бичнэ.

5.4. Тэргүүлэгчдээс гарах шийдвэр нь тогтоол байх бөгөөд зарим асуудалд тэмдэглэлээр шийдвэр гаргаж болно. Тогтоолд ИТХ-ын дарга гарын үсэг зурна.

5.5. Хуралдаанаас гарах шийдвэрийг ажлын 3 хоногт багтаан ёсчилон гаргана.

5.6. Хуралдааны баримтжуулсан материалд хэлэлцсэн асуудлын төлөвлөгөө, жагсаалт хуралдааны тэмдэглэл, илтгэл, сонсгол, танилцуулга, гаргасан шийдвэр багтана.

5.7. Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудал албан байгууллага, иргэний нэр төр нууцлалтай холбоотой байвал Тэргүүлэгчид болон хуралд оролцогчид нууцыг чанд хадгална.

5.8. Хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар төв болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх үүргийг ИТХ-ын нарийн бичгийн дарга хариуцна.

**Зургаа. Тэргүүлэгчдийн ажлыг дүгнэх үзүүлэлтүүд**

6.1 Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцсон байдал /ирц, таслалт, хожимдолт/

6.2 Тэргүүлэгчид хариуцсан бодлогын хороогоор асуудал хэлэлцүүлж, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байдал

6.3 Хэлэлцсэн асуудлаар ажил хэрэгч санал, оновчтой шийдлийн хувилбар дэвшүүлсэн байдал

6.4 Санаачилгаараа асуудал дэвшүүлж судлан боловсруулж хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн байдал

6.5 Ажил үүргийн хуваарь, төлөвлөгөөгөөр хариуцсан үүргийн биелэлт, үр дүн

6.6 ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал бэлтгүүлж оруулах ажлын хэсэгт ажиллаж гарах шийдвэрийн төсөл, санал дүгнэлт гаргах зэрэг ажилд оролцсон байдал

6.7 Гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, биелэлтийг хянан шалгах ажилд оролцсон байдал

6.8 Сум багийн хуралд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн байдал

6.9 Иргэдийн санал хүсэлтийг судлах, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, зохиосон ажлаа тайлагнах, хурлын шийдвэр, төр засгийн бодлого зорилт, хууль тогтоомжийг сурталчлах, төлөөлөгчийн нэг өдөр зохион байгуулах зэргээр иргэд сонгогчидтойгоо ажилласан байдал

6.10 Хурлын даргаас тусгайлан өгсөн үүрэг даалгаврын биелэлт

6.11 Дээрх үзүүлэлтээр нэгтгэн гаргасан самбарыг ил тавьж иргэд сонгогчдод нээлттэй мэдээлнэ.

6.12 Мөн дээрх үзүүлэлтээр гаргасан мэдээллийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд хагас бүтэн жилээр хүргүүлнэ.

**Долоо. Хариуцлага**

7.1 Тэргүүлэгч Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцох боломжгүйгээ ИТХ-ын даргад урьдчилан мэдэгдэж чөлөө аваагүй, бусад хүндэтгэх шалтгаангүйгээр 3 ба түүнээс дээш хурал тасалсан, 5 ба түүнээс дээш 30 минутаас дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд ИТХ-ын Тэргүүлэгчээс чөлөөлөх саналыг намын бүлэгт нь тавина.

**Найм. Бусад асуудал**

8.1 Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах, журмыг хүчингүй болгохдоо Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрээр шийдвэрлэнэ.

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.04.16 № 54 Номгон

## Нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицол батлах тухай

Аймгийн ИТХ-ын ээлжит бус ҮIII хуралдааны 8/4 дүгээр тогтоолоор баталсан "Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд 2014 онд нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хавсралтаар тогтоосон газруудыг аймаг, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулан батлуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014
оны 54 дугаар тогтоолын хавсралт

## 2014 ОНД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ГАЗАР, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, СОЛБИЦОЛ

| Д/Д | Сумдын нэр | Газрын нэр | Талбайн хэмжээ / га / | Байршил солбицол | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | № | E | | | N | | |
| 1 | Баян-Овоо | Хоёрдугаар баг, Ташаа-1 | 13 | Ташаа – 1.1 | | | | | | |
| | | | | 1 | 100 | 24 | 54,0 | 46 | 59 | 56,4 |
| | | | | 2 | 100 | 25 | 1,2 | 46 | 59 | 53,16 |
| | | | | 3 | 100 | 25 | 4,8 | 46 | 59 | 52,8 |
| | | | | 4 | 100 | 25 | 1,2 | 46 | 59 | 44,88 |
| | | | | 5 | 100 | 24 | 50,4 | 46 | 59 | 49,56 |
| | | | | 6 | 100 | 24 | 43,2 | 46 | 59 | 48,12 |
| | | | | 7 | 100 | 24 | 39,6 | 46 | 59 | 43,8 |
| | | | | 8 | 100 | 24 | 32,4 | 46 | 59 | 51,36 |
| | | | 39,2 | Ташаа – 1.2 | | | | | | |
| | | | | 9 | 100 | 26 | 6,0 | 46 | 0 | 5,76 |
| | | | | 10 | 100 | 25 | 58,8 | 46 | 0 | 3,24 |
| | | | | 11 | 100 | 25 | 55,2 | 46 | 0 | 2,16 |
| | | | | 12 | 100 | 25 | 44,4 | 46 | 0 | 1,8 |
| | | | | 13 | 100 | 25 | 37,2 | 46 | 59 | 59,28 |
| | | | | 14 | 100 | 25 | 33,6 | 46 | 59 | 57,84 |
| | | | | 15 | 100 | 25 | 22,8 | 46 | 59 | 51 |
| | | | | 16 | 100 | 25 | 19,2 | 46 | 59 | 48,84 |
| | | | | 17 | 100 | 25 | 15,6 | 46 | 59 | 42 |
| | | | | 18 | 100 | 25 | 15,6 | 46 | 59 | 35,16 |
| | | | | 19 | 100 | 25 | 8,4 | 46 | 59 | 33 |
| | | | | 20 | 100 | 25 | 4,8 | 46 | 59 | 21,48 |
| | | | | 21 | 100 | 25 | 1,2 | 46 | 59 | 13,56 |
| | | | | 22 | 100 | 24 | 50,4 | 46 | 59 | 6,72 |
| | | | | 23 | 100 | 24 | 32,4 | 46 | 59 | 8,16 |
| | | | | 24 | 100 | 24 | 28,8 | 46 | 59 | 3,48 |
| | | | | 25 | 100 | 24 | 21,6 | 46 | 59 | 6 |
| | | | | 26 | 100 | 24 | 21,6 | 46 | 59 | 10,32 |
| | | | | 27 | 100 | 24 | 32,4 | 46 | 59 | 12,48 |
| | | | | 28 | 100 | 24 | 1356,0 | 46 | 59 | 9,24 |
| | | | | 29 | 100 | 24 | 50,4 | 46 | 59 | 10,68 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 30 | 100 | 24 | 57,6 | 46 | 59 | 14,28 |
| | | | | 31 | 100 | 25 | 8,4 | 46 | 59 | 41,28 |
| | | | | 32 | 100 | 25 | 1392,0 | 46 | 59 | 43,08 |
| | | | | 33 | 100 | 25 | 19,2 | 46 | 59 | 52,08 |
| | | | | 34 | 100 | 25 | 19,2 | 46 | 59 | 57,48 |
| | | | | 35 | 100 | 25 | 15,6 | 46 | 59 | 59,64 |
| | | | | 36 | 100 | 25 | 19,2 | 46 | 0 | 2,16 |
| | | | | 37 | 100 | 25 | 22,8 | 46 | 0 | 2,16 |
| | | | | 38 | 100 | 25 | 26,4 | 46 | 6 | 36 |
| | | Хоёрдугаар баг, Ташаа-2 | 42,8 | **№** | **E** | | | **N** | | |
| | | | | Ташаа-2 | | | | | | |
| | | | | 1 | 100 | 26 | 4,5 | 46 | 0 | 5,7 |
| | | | | 2 | 100 | 26 | 0,1 | 46 | 0 | 3,5 |
| | | | | 3 | 100 | 25 | 53,5 | 46 | 0 | 2,1 |
| | | | | 4 | 100 | 25 | 44,5 | 46 | 0 | 1,5 |
| | | | | 5 | 100 | 25 | 36,0 | 46 | 59 | 59,2 |
| | | | | 6 | 100 | 25 | 33,1 | 46 | 59 | 57,9 |
| | | | | 7 | 100 | 25 | 23,5 | 46 | 59 | 51,0 |
| | | | | 8 | 100 | 25 | 21,3 | 46 | 59 | 48,6 |
| | | | | 9 | 100 | 25 | 19,7 | 46 | 59 | 45,3 |
| | | | | 10 | 100 | 25 | 18,0 | 46 | 59 | 43,5 |
| | | | | 11 | 100 | 25 | 16,3 | 46 | 59 | 41,9 |
| | | | | 12 | 100 | 25 | 13,9 | 46 | 59 | 35,2 |
| | | | | 13 | 100 | 25 | 10,8 | 46 | 59 | 34,3 |
| | | | | 14 | 100 | 25 | 7,8 | 46 | 59 | 32,9 |
| | | | | 15 | 100 | 25 | 5,4 | 46 | 59 | 25,7 |
| | | | | 16 | 100 | 25 | 4,2 | 46 | 59 | 21,5 |
| | | | | 17 | 100 | 25 | 1,8 | 46 | 59 | 17,6 |
| | | | | 18 | 100 | 25 | 0,1 | 46 | 59 | 13,7 |
| | | | | 19 | 100 | 24 | 55,5 | 46 | 59 | 10,3 |
| | | | | 20 | 100 | 24 | 30,8 | 46 | 59 | 12,2 |
| | | | | 21 | 100 | 24 | 33,2 | 46 | 59 | 8,2 |
| | | | | 22 | 100 | 24 | 28,8 | 46 | 59 | 3,8 |
| | | | | 23 | 100 | 24 | 22,2 | 46 | 59 | 6,2 |
| | | | | 24 | 100 | 24 | 21,5 | 46 | 59 | 10,4 |
| | | | | 25 | 100 | 24 | 25,0 | 46 | 59 | 10,6 |
| | | | | 26 | 100 | 24 | 28,5 | 46 | 59 | 11,5 |
| | | | | 27 | 100 | 24 | 34,7 | 46 | 59 | 9,2 |
| | | | | 28 | 100 | 24 | 45,1 | 46 | 59 | 6,9 |
| | | | | 29 | 100 | 24 | 51,3 | 46 | 59 | 6,6 |
| | | | | 30 | 100 | 24 | 55,3 | 46 | 59 | 11,0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 31 | 100 | 24 | 57,0 | 46 | 59 | 14,2 |
| | | | | 32 | 100 | 25 | 0,2 | 46 | 59 | 21,0 |
| | | | | 33 | 100 | 25 | 3,6 | 46 | 59 | 29,0 |
| | | | | 34 | 100 | 25 | 5,2 | 46 | 59 | 34,6 |
| | | | | 35 | 100 | 25 | 7,3 | 46 | 59 | 36,8 |
| | | | | 36 | 100 | 25 | 7,3 | 46 | 59 | 40,8 |
| | | | | 37 | 100 | 25 | 12,1 | 46 | 59 | 42,7 |
| | | | | 38 | 100 | 25 | 18,7 | 46 | 59 | 52,1 |
| | | | | 39 | 100 | 25 | 19,7 | 46 | 59 | 57,2 |
| | | | | 40 | 100 | 25 | 15,8 | 46 | 59 | 59,7 |
| | | | | 41 | 100 | 25 | 18,2 | 46 | 0 | 1,8 |
| | | | | 42 | 100 | 25 | 21,8 | 46 | 0 | 2,1 |
| | | | | 43 | 100 | 25 | 24,9 | 46 | 0 | 3,6 |
| | | Хоёрдугаар баг, Алтан Ус-1 | 46,2 | **№** | **E** | | | **N** | | |
| | | | | Алтан Ус-1. | | | | | | |
| | | | | | 100 | 27 | 43,2 | 46 | 3 | 5,8 |
| | | | | | 100 | 27 | 57,6 | 46 | 3 | 5,0 |
| | | | | | 100 | 28 | 1,2 | 46 | 3 | 50,6 |
| | | | | | 100 | 27 | 50,4 | 46 | 3 | 46,0 |
| | | | | | 100 | 27 | 46,8 | 46 | 3 | 43,8 |
| | | | | | 100 | 27 | 39,6 | 46 | 3 | 44,2 |
| | | | | | 100 | 27 | 28,8 | 46 | 3 | 36,6 |
| | | | | | 100 | 27 | 21,6 | 46 | 2 | 28,0 |
| | | | | | 100 | 27 | 18 | 46 | 2 | 26,2 |
| | | | | | 100 | 27 | 25,2 | 46 | 3 | 35,5 |
| | | | | | 100 | 27 | 36 | 46 | 3 | 54,2 |
| | | | | | 100 | 27 | 46,8 | 46 | 3 | 48,1 |
| | | | | | 100 | 27 | 18 | 46 | 2 | 20,8 |
| | | | | | 100 | 27 | 18 | 46 | 2 | 20,0 |
| | | | | | 100 | 27 | 10,8 | 46 | 2 | 8,5 |
| | | | | | 100 | 27 | 10,8 | 46 | 2 | 6,4 |
| | | | | | 100 | 26 | 52,8 | 46 | 2 | 58,1 |
| | | | | | 100 | 26 | 34,8 | 46 | 2 | 57,0 |
| | | | | | 100 | 26 | 20,4 | 46 | 2 | 53,0 |
| | | | | | 100 | 26 | 20,4 | 46 | 2 | 56,3 |
| | | | | | 100 | 26 | 38,4 | 46 | 2 | 0,2 |
| | | | | | 100 | 27 | 7,2 | 46 | 2 | 7,8 |
| | | | | | 100 | 27 | 14,4 | 46 | 2 | 22,6 |

<table>
<tr><td></td><td></td><td>Хоёрдугаар баг, Алтан Ус-2</td><td>36</td><td>

| № | E | | | N | | |
|---|---|---|---|---|---|---|
| Алтан Ус-2 | | | | | | |
| | 100 | 28 | 4,8 | 46 | 2 | 44,9 |
| | 100 | 28 | 8,4 | 46 | 2 | 35,9 |
| | 100 | 28 | 12 | 46 | 2 | 30,5 |
| | 100 | 28 | 19,2 | 46 | 2 | 26,9 |
| | 100 | 28 | 15,6 | 46 | 2 | 10,3 |
| | 100 | 28 | 1,2 | 46 | 2 | 7,4 |
| | 100 | 27 | 50,4 | 46 | 2 | 10,0 |
